



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн “Эрхэм” эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг хавсралтын дагуу бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Бодь даатгал” ХХК /Б.Золбаяр/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Бодь даатгал” ХХК /Б.Золбаяр/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2020 оны 2/сарын 29 өдрийн
33-р тогтоолын хавсралт

Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Бодь даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	“Эрхэм” эрүүл мэндийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал
4.	Даатгалын зүйл	Даатгуулагчийн ажиллагсад болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд
5.	Даатгалын эрсдэл	1. Хурц өвчлөл 2. Архаг хууч өвчний эмчилгээ 3. Гэнэтийн ослоос үүдэлтэй эмчилгээ
6.	Даатгалын гэрээний хугацаа	Харилцан тохиролцоно
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	15 бүлэг, 117 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн шийдвэр
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	А.Бүжин
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгалын газрын захирал Б.Хүдэртулга, даатгалын ахлах менежер Р.Гэрэл